

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН АЮУЛГҮЙН БАЙДЛЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

Д.Өлзийбат

ШШГЕГ-ЫН 435 дугаар хаалттай
хорих ангийн дарга, докторант,
хурандаа

Товч утга: Хорих байгууллагын аюулгүй байдал болон харуул хамгаалалтын асуудал хоорондоо нягт уялдаа холбоотой байж, түүний оршин тогтнох, үйл ажиллагаагаа хэвийн явуулах, боловсронгуй болгох, цаашлаад хөгжин дэвжих хэрэгцээнд суурилсан байхын зэрэгцээ *“...ял эдлүүлэх ажиллагааг тасралтгүй явуулах, гадна, дотнын сөрөг нөлөөлөл, болзошгүй аюул, эрсдэлийг урьдчилан судлах, сэргийлэх, хор аюулыг хэмжээг үнэлэх, бууруулах, таслан зогсоох, арилгах...”* зэрэг цогц арга хэмжээний үр дүнгээр илэрхийлэгдэг. Энэ ч утгаараа хорих байгууллагын аюулгүй байдал, харуул хамгаалалтад тулгамдаж буй асуудлыг судалгааны үндсэн дээр нээн илрүүлэх, чиг баримжааг тодорхойлох цаг үеийн хэрэгцээ шаардлага байна

Түлхүүр үгс: Хорих байгууллагын аюулгүй байдал, аюул, эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, нээн илрүүлэх, таслан зогсоох,

Нэг. Үндсэн хэсэг

Аюулгүй байдлын салбар хурдацтай хувьсан өөрчлөгдөж байна. Монголчууд бид алсын гийчин, морин улаач/өртөөч/-ийг сайн явж ирэв үү? гэж угтдагаас хурдан явж ирэв үү? гэж угтаж бас үддэггүй ард түмэн¹. Энэ бидний нүүдэлчин соёл иргэншил, ахуй, аюулгүй байдлыг хангаж ирсэн суурь ойлголттой холбоотой.

Нийгэм эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжиж буй сүүлийн жилүүдэд гэмт хэргийн тоон үзүүлэлт өсөхийн хамт, гэмт үйлдлийн арга нарийсаж, илүү хор аюултай, зохион байгуулалттай, улс төр, бизнесийн салбар, эрүүгийн гэмт бүлэглэлүүд шинээр үүсэж, гэмт явдлын нөхцөл байдал хүндэрсээр байна².

Судлаачийн зүгээс хорих байгууллагын үйл ажиллагаа буюу хорих ял эдлүүлэх ажиллагааг хөгжин өөрчлөгдөж буй шинжлэх ухааны орчин үеийн чиг хандлагад нийцүүлж, хоригдлоос гадна бусад хүчин зүйл /ард иргэд, төр нийгмийн байгуулал, хүрээлэн буй орчны зэрэг/ бүхий л хүчин зүйлсийн аюул, эрсдэлийн түвшинг ул суурьтай судалж, тогтоох, аюулгүй байдлын тухай онол, сургаалтай уялдуулан авч үзэж хөгжүүлэх шаардлагатай гэж үздэг.

Аюулгүй байдлын ухаан нь хүн, нийгэм, төр улс болон байгаль, дэлхийн оршин тогтнох зүй тогтол дахь үнэт зүйлсийг хамгаалан хөгжүүлэх

¹ Доктор (Ph.d) Д.Адъяабазар. Байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангахад шинэ хандлага чухал. ШШГЕГ-ын Сүлд-Инфо сэтгүүл. 2016. Дугаар 2, 26 дахь тал.

² Доктор (Phd) Ц.Очгэрэл. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтцолцоог боловсронгуй болгох асуудал” сэдэвт докторын судалгааны ажил. 2015 он. УБ., 1-4 дэх тал.

шаардлагад тулгуурладаг бөгөөд аюулгүй байдал судлалыг учирч болох аюул, заналын шинж чанар өөрчлөгдөн хувьсаж, илүү даяарших шинжтэй болсон өнөөгийн цаг үед аюулаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг бууруулах, арилгах талаар бие даасан өвөрмөц судлагдахуун бүхий судлал болохын зэрэгцээ аюулгүй байдлын судалгааны объект нь улс орны дотоод, гадаад байдал, улс төрийн бодлого, нийгэм, хүрээлэн буй орчин³ гэж үзэх хандлага түгээмэл байдаг.

Монгол Улсын хувьд 1900 оны үеэс батлан хамгаалах салбарын судлаач, эрдэмтдийн зүгээс аюулгүй байдлын ухааныг гүнзгийрүүлэн судалж эхэлсэн бөгөөд аюулгүй байдал судлал нь төр, хувийн хэвшил, өрх гэр, бие хүний зэрэг бүхий л түвшинд өргөнөөр нэвтэрч, тэдгээрийн ашиг сонирхол, хэрэгцээнд суурилан хөгжсөөр байна.

Аюулгүй байдлын тухай ойлголтыг манай улсын зарим судлаачийн зүгээс гурван зүйл үзэгдлийн хамраалд авч үзсэн байдаг. Тухайлбал:

1. Аюул занал байхгүй нөхцөл;
2. Үүссэн аюул заналд тухайн объект тогтвортой байдлаа хадгалах чадвар, халдашгүй дархан байдал, найдвартай байдлын нөөц;
3. Заналхийллээс хамгаалах, түүнийг таслан зогсоох, анхны байдлаа эргүүлж тогтоох бэлэн байдал, чадварын түвшин юм.

Манай улсын аюулгүй байдлын чиглэлийн судлаач, эрдэмтдийн бүтээлд тус байдлын энд авч үзье. Тухайлбал, судлаач, эрдэмтэн А.Сүхбаатар аюулгүй байдал гэдгийг “төр нийгмийн, бие хүний /иргэний/ аюулгүй байдал түүхэн тодорхой нөхцөлд гадаад дотоодын бодит болон болзошгүй аюулаас үндэсний язгуур эрх ашиг найдвартай хангагдсан байдал”⁴ гэсэн бол судлаач, эрдэмтэн Ж.Бор аюулгүй байдал гэдгийг “эрсдэл нөхцөл байдалд амьдрах чадвар бүхий системийн үнэт зүйлийг хамгаалах, хөгжих боломжийг хангах баталгаа” хэмээн тус тус тодорхойлсон байна.

Эндээс аюулгүй байдал гэдгийг судлаачийн зүгээс аюулгүй байдлын асуудлыг дараах байдлаар тодорхойлохыг эрмэлзсэн. Аюулгүй байдал гэдэг нь **“Нийгмийн байгууллын институт /бүтэц/ тэдгээрийн хөгжил дэвшлийн явц, тогтвортой байдал, цаашдын оршин тогтнох баталгаа зэргийг илэрхийлэх цогц ойлголт”** гэж үзэж болохоор байна.

Аюулгүй байдлын онолын асуудал нь хэдийгээр нэгдсэн нэг ойлголтод хүрээгүй ч дотоодын болон гадаад улс орны эрдэмтэн судлаачдын зүгээс аюулгүй байдал хэмээх ойлголтын талаар өөрсдийн санааг дэвшүүлсэнд дүгнэлт хийж үзвэл:

1. Хүнд учрах ямар нэг аюул байхгүй байх, хүний амьдрах хэвийн нөхцөл хангагдах⁵

³ А.Сүхбаатар. Аюулгүй байдал, батлан хамгаалах, цэргийн стратеги, гадаад, дотоод бодлогын үндсэн асуудал. УБ., 2004. 54 дэх тал

⁴ Мөн тэнд. 55 дахь тал

⁵ Монгол улсын Их хурлын 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоол, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УИХ-ын Тамгын газрын хэвлэх цех., УБ., 2010. 16 дахь тал.

2. Аюулгүй байдал нь хүний болон төрийн зайлшгүй шаардлагатай суурь хэрэгцээ болох⁶

3. Аюулаас найдвартай хамгаалагдсан байх, аюул занал арилсан байх

4. Дотоод, гадаад хүчин зүйлээс хамааралтай байх

5. Төрийн зүгээс аюулгүй байдлыг хангах нөхцөл, аюул, заналхийллийн түвшнийг ангилан үнэлж, түүнээс урьчилан сэргийлэх механизм бүрдүүлэх⁷

6. Аюулгүй байдлаа хангах тогтвортой, цогц арга хэмжээний үр дүн байх⁸

7. Аюул, заналын гол объект нь хүн байхын зэрэгцээ эргээд аюул занал хүний хүчин зүйлээс бий болдог

8. Шинжлэх ухааны хэд хэдэн салбарын судлагдахуун болохын зэрэгцээ объектын шинж чанараас шалтгаалан өөр өөр түвшинд хамааруулан авч үзэх шаардлагатай байдаг зэрэг шинжүүдийг дурдаж болно.

Хоёр. Хорих байгууллагын аюулгүй байдлын ойлголт, үндсэн асуудал

Аюулгүй байдлын онолын ухагдахууны агуулга, онцлог шинжүүд, харилцан хамаарах байдал зэрэгт тулгуурлан хорих байгууллагын аюулгүй байдлын ухагдахууныг харьцуулан тодорхойлох нь хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах тогтолцооны онолын үндэс, арга зүйн суурь ойлголт болох ач холбогдолтой гэж судлаачийн зүгээс үздэг.

Хоригдогсод бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг үйлдэх, хорих байгууллагаас харуул хамгаалалтын дутагдалтай байдал, сул талыг ашиглан хамгаалалтын инженер-техникийн хэрэгслийг эвдэх, зориулалтын саад, төхөөрөмжийг давж туулах замаар ганцаар болон бүлэглэн оргох гэмт хэргийг үйлдэгдсээр ирсэн болохыг албан ёсны тоо баримт, мэдээллээс харж болно.

Хэдийгээр гүйцэтгэх ажлын арга, хэрэгслээр хоригдлыг зүгээс гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлийг нээн илрүүлж, таслан зогсоох боломжтой ч хууль, журамд туссан нийцлийн эрх зүйн зохицуулалтын эрсдэл их, харуул хамгаалалтын хүч, хоригдлын тооноос харьцангуй бага, үйл ажиллагаанд ашиглагдаж буй харуул хамгаалалтын тоног төхөөрөмж стандартын шаардлага хангахгүй тохиолдолд учирч болох хор уршгийг хангалттай хэмжээнд арилгах, таслах зогсоох боломж хомс байна.

Хорих байгууллагын аюулгүй байдлын ойлголт, онолын ухагдахууныг судлан шинжлэх шаардлагыг дараах зургаан чиглэлд авч үзэж болно. Үүнд:

1. Хорих байгууллагын аюулгүй байдлын ойлголт, ухагдахууныг судлан гаргах.

⁶ Ж.Бор. Жижиг улс ба Үндэсний аюулгүй байдал. Жижиг улсын аюулгүй байдал. Өнөө ирээдүй эмхтгэл. УБ., 2010. 128 дахь тал

⁷ Ж.Энхбаяр. Аюулгүй байдлын олон талт асуудал. УБ., 2007. 8 дахь тал

⁸ Ж.Бор. Дурдсан бүтээл. 170 дахь тал

2. Хорих байгууллагын аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтын уламжлал, шинэчлэлд дүн шинжилгээ хийх.

3. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах тогтолцоог Монгол улсын дотоод аюулгүй байдалтай хэрхэн харилцан хамаарахыг шинжлэх.

4. Гадаадын зарим улс орны хорих байгууллагын тогтолцоо, эрх зүйн зохицуулалттай харьцуулан судлан, давуу талыг нэвтрүүлэх.

5. Хорих ангийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг шинэчлэн судлах.

6. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцооны зүй тогтлыг судлах зэрэг болно.

Судлаач, эрдэмтэн доктор (Ph.d) Ц.Очгэрэл өөрийн бүтээлдээ хорих байгууллагын аюулгүй байдал гэдгийг “Хорих байгууллагын гадаад, дотоод сөрөг нөлөөллөөс хамгаалагдах хэрэгцээ хангагдаж, аюул, занал, эрсдэлт нөхцөл байдлыг урьдчилан судлах, үнэлэх, хор аюулыг бууруулах, таслан зогсоох, арилгах, урьдчилан сэргийлэх зорилт бүхий цогц арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж, үйл ажиллагаагаа хэвийн тогтвортой явуулах, хөгжих нөхцөл бүрдсэн байхыг”⁹ хэлнэ гэж тодорхойлсон байна.

Эндээс өргөн утгаараа хорих байгууллагын аюулгүй байдал нь байгууллагын оршин тогтнох, хөгжих хэрэгцээнд суурилсан байхын зэрэгцээ ял эдлүүлэх ажиллагаа тасралтгүй, амжилттай хэрэгжих явц, зорилтод сөрөг нөлөөлөл үзүүлэх, ноцтой хор уршиг учруулж болзошгүй аюул, эрсдэлийг урьдчилан судлах, үнэлэх, хор аюулыг бууруулах, таслан зогсоох, арилгах, урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээний үр дүнгээр илэрхийлэгдэж байна.

Аюулгүй байдлын онолын асуудал, эрдэмтэн, судлаачдын бүтээлд уяж, судлаачийн зүгээс **“хорих ангийн аюулгүй байдлын асуудал”**-ыг нэгдүгээрт, “хорих байгууллага дахь гүйцэтгэх ажил, хоёрдугаарт, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, гуравдугаарт, **харуул хамгаалалтын үйл ажиллагааны нэгдсэн цогц ойлголт**” гэж үзэж байна. Дээрх үндсэн асуудлыг тусад нь салгаж, хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах боломжгүй гэдэгтэй судлаачийн зүгээс санал нийлж байна.

Хэрэгжүүлж буй үйл ажиллагааны онцлогоос хамааран хорих байгууллагын аюулгүй байдлын объектыг нэгдүгээрт, “хорих анги, цагдан хорих байр”, хоёрдугаарт, ажилтан, алба хаагч, гуравдугаарт, сэжигтэн, яллагдагч, хоригдол, бусад хүмүүс гэж хэсэгт хуваан авч үзнэ.

1. Хорих анги, цагдан хорих байр

Хорих анги, цагдан хорихын аюулгүй байдал хангах тухай ойлголтод аюулгүй байдлын шаардлагын үүднээс дараах хэсгүүдийг хамруулан авч үзнэ. Үүнд:

- Хорих анги, цагдан хорих байрны үйл ажиллагаа гадаад, дотоод сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс ангид байх буюу хэвийн явагдах нөхцөл хангагдсан байх.

- Хоригдол болон бусад этгээдийн зүгээс хорих байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн гэмт хэрэг, зөрчил, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, ноцтой гэмт зорилго

⁹ Ц.Очгэрэл. Хорих байгууллагын аюулгүй байдал. УБ. 2017. 36 дахь тал

бүхий нуугдмал санаа, төлөвлөлтийг илрүүлэх арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байх.

- Хүрээлэн байгаа орчны буюу байгалийн гамшиг, эрсдэлээс үүсэх үр дагавраас хамгаалагдсан байх чадавхыг хангах асуудал нь хорих байгууллагын аюулгүй байдлын нэг үндсэн чиглэл байна.

- Хорих анги, цагдан хорих байрны барилга байгууламж, хамгаалалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн байнгын найдвартай ажиллагаа, эдийн засгийн аюулгүй байдал буюу санхүүгийн болон бусад материаллаг хангамж тасралтгүй хангагдсан байдал.

- Боловсон хүчний хангамж, ажилтан, албан хаагчийн мэргэжлийн ур чадвар, анхан шатны болон давтан сургалт.

- Төрийн нууцын хадгалалт, хамгаалалтын хэвийн ажиллагаа.

2. Ажилтан, албан хаагчид.

- Хорих байгууллагын аюулгүй байдлын нэг үндсэн объект бөгөөд сэжигтэн, яллагдагч, хоригдол нь “гэмт санаа бодлоо амжилттай хэрэгжүүлэх, нуун далдлах, өөрийн хань хамсаатантай холбоо тогтоох” зэрэг сөрөг үйлдлийнхээ явцад ажилтан, албан хаагчийн аюулгүй байдалд шууд болон шууд бусаар халдах бодит аюул түгээмэл байдаг.

3. Сэжигтэн, яллагдагч, ялтан /хоригдол/ бусад хүмүүс.

- Сэжигтэн, яллагдагч, ялтны /хоригдол/ зүгээс хамт хоригдогсдын амь нас, эрүүл мэндэд халдах, тэднийг дарамтлах зэрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсээр байна. Түүнчлэн эрүүгийн хариуцлагаас зайлсхийх зорилгоор, сэтгэл зүйн онцлог, бусад шалтгааны улмаас амиа хорлох, бие эрхтэндээ гэмтэл учруулах зэрэг ноцтой үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохын тулд тэдний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах асуудлыг нэгдүгээрт, аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалт, хоёрдугаарт, техникийн хяналт, хамгаалалт, гуравдугаарт, биечилсэн хяналт, хамгаалалт, эцсийн бүлэгт, аюулгүй байдлын түвшин, эрсдэлийг үнэлэх гэж тус тус ангилж авч үзсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 242 дугаар зүйлд “Аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтын асуудал”-ыг дараах байдлаар томъёолсон байна.Үүнд:

- Нэгдүгээрт, “шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үүрэг бүхий тусгай ажиллагааны нэгжтэй байна”.

- хоёрдугаарт, “хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, хорих ял эдлүүлэх алба нь хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудтай дараах чиглэлээр хамтран ажиллана”.

- гутгаарт, “хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны аюулгүй байдалд нөлөөлөх аюул, эрсдэлийн мэдээлэл солилцох” асуудал;

- дөрөвдүгээрт, “хорих ангид онцгой нөхцөл үүссэн үеийн харилцан ажиллагаа, тусгай техник, хэрэгсэл, мэргэжлийн дэмжлэг авах” тухай зохицуулалт;

- тавдугаарт, “оргосон хоригдол, хоригдсон этгээдийг эрэн сурвалжлах, алба хаагчийн аюулгүй байдлыг хангахад туслалцаа авах”, “хоригдол, хоригдсон этгээдийг нүүлгэн шилжүүлэх, хуяглан хүргэх ажиллагаанд дэмжлэг авах” асуудал;

- эцсийн дугаарт, “хорих ангийн аюулгүй байдлын техник, тусгай хэрэгсэл, ажиллагааны зардлыг тооцон жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлнэ” гэж тус тус заасан байна.

Мөн хуулийн 243 дугаар зүйлд байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, хорих анги, байгууллагад гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, асуудлыг дараах байдлаар зохицуулсан. Үүнд:

- “Хорих ангийн техникийн хяналт, хамгаалалт” гэсэн хэсэгт хорих анги нь гадна хориотой бүс, хамгаалалтын хашаа, дулаан, хөдөлгөөн мэдрэгч дохиолол, цахилгаан хүчдэлийн шугам, дүрс бичлэгийн хяналт бүхий зурвас, нэвтрэх хэсгийн дуу-дүрсний бичлэгийн хяналт бүхий бүс хамгаалалтын дараах бүстэй байна;

- Хорих ангийн гадна хориотой бүс нь хоригдлын амьдралын бүсээс хот суурин газарт 500 метр, хөдөө орон нутагт 1000 метр байна. Хаалттай хорих анги нь хамгаалалтын хашааны гадна талд дүрс бичлэгийн төхөөрөмжөөр тоноглогдсон хяналтын цамхагтай байна.

- Хамгаалалтын бүсэд дуу-дүрсний бичлэгийн техник хэрэгсэл ашиглан хяналт тавих бөгөөд хорих байгууллага, байр, өрөөнд нэвтрэх хэсэгт хамгаалалтын хаалттай байна.

- Хорих ангийн аюулгүй байдлыг хангахад албаны нохой ашиглахаар тус тус зохицуулсан.

Түүнчлэн мөн хуулийн 244 дүгээр зүйлийн 244.1-т “хорих анги, байгууллагын аюулгүй байдлыг хангах зорилгоор хорих анги, түүний ойр орчимд үүрэн холбооны хэрэгслийн сүлжээ сарниулах тоног төхөөрөмж ашиглахаар”.

- Хорих ангийн “биечилсэн хяналт, хамгаалалт”-ын тухайд “биечилсэн хяналт, хамгаалалт, нээлттэй болон хаалттай хорих ангийн дохиолол, гадна хамгаалалтыг хорих ангийн алба хаагчдын хүчээр зохион байгуулахаар;

- Хамгаалалтын ажилтан нь хоригдол, хорих байгууллагад нэвтэрч байгаа хүний бие эд зүйл, техник хэрэгсэлд өдөр, шөнийн аль ч цагт үзлэг, нэгжлэг хийхээр тус тус зохицуулсан байна.

Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх тухайд “хорих ангийн алба хаагч онцгой нөхцөл байдал үүссэн үед ашиглагдах нэг бүрийн хамгаалах тусгай хэрэгслээр хангагдана”, “хорих ангийн албан хаагч үүргээ гүйцэтгэх үедээ биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсгийг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэх тухай зохицуулсан байна.

Мөн хуулийн 248 дугаар зүйлийн 248.1-т “эрх бүхий алба хаагч гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хорих ангид гүйцэтгэх ажил явуулна”, “хорих ангид гүйцэтгэх ажил явуулах журам, зааврыг гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжид нийцүүлэн тагнуулын төв байгууллагын дарга шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргатай зөвшилцөн батална” гэж заасан байна.

Хорих ангид онцгой дэглэм тогтоох асуудлыг дараах байдлаар зохицуулсан. Үүнд:

- “гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон”, “тахал, гоц халдварт болон олон улсын хөл хориот өвчин гарсан”, “нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон”, “хорих байгууллагад зэвсэглэн халдсан” тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга 30 хүртэл хоногийн хугацаагаар онцгой дэглэм тогтоож болно;

- Хорих ангид тогтоосон онцгой дэглэмийг түүнийг тогтоосон албан тушаалтан цуцлах бөгөөд энэ хуулийн 249.1-д заасан үндэслэл арилаагүй тохиолдолд 30 хүртэл хоногоор сунгана;

- Хорих ангид онцгой дэглэм тогтоосон үед хоригдлын оролцоотой зохион байгуулагддаг бүх үйл ажиллагааг зогсоох бөгөөд хорих ангийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг нэмэгдүүлж, эргэлт, уулзалт, захидал харилцааг хориглох, хорих ангийн өдрийн цагийн хуваарийг өөрчилж болно гэж тус тус хуульчилж өгсөн байна.

Түүнчлэн “Хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, аюулгүйн тойрог тогтоох журам”-ыг 2017 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/92, А/81 дугаар хамтарсан тушаалаар баталсан нь явдал байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах шинэлэг зохицуулалт болсон гэдэгтэй судлаачийн зүгээс санал нэг байна.

Гурав. Хорих байгууллагын аюулгүй байдал, харуул хамгаалтад тулгамдаж буй зарим асуудал:

1. Аюулгүй байдлыг хангах удирдлага, зохион байгуулалт

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны удирдлагууд өдөр тутмын үйл ажиллагаандаа аюулгүй байдал, эрсдэлийг өргөн хүрээнд харж зохион байгуулалтын арга хэмжээ авах байдал орхигдсон. Төсөв хөрөнгөнд баригдан бодит эрсдэлтэй эвлэрч шийдвэртэй арга хэмжээ авагддаггүй зогсонги байдалд орсон. Бусад аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хөгжлөөс хоцорсон, аюулгүй байдлын хангах бие даасан төрөл мэргэжлийн албаны мэргэжлийн чадавх сул, үүсэж бэхжих эхний шатандаа байна.

2. Онцгой нөхцөл бий болсон үед ажиллах төлөвлөлт, бэлэн байдал

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны онцгой нөхцөл байдлын үед ажиллах төлөвлөгөө харилцан адилгүй боловсруулагдсан, бэлэн байдалд шаардагдах хүч хэрэгслийн тооцоо хангалтгүй, дадлага сургуулилт тогтмолжоогүй, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай харилцан ажиллах нэгдсэн ойлголтод хүрээгүй, төсөв, зардал бүрэн шийдвэрлэгдээгүй зэргээс онцгой нөхцөл бий болсон үед ажиллах бэлтгэл хангагдаагүй, үүрэг гүйцэтгэх чадамж бүрдээгүй байна.

3. Объектын аюулгүй байдал

Объектын аюулгүй байдлыг хангах нэгдсэн төлөвлөгөө, схем зурагтай хэдий ч тухайн орон нутгийн онцлог, байршлаас хамаарч хамгаалалт, аюулгүй байдлын шаардлага хангасан барилгын шийдэлгүй, эрсдэлийг тогтоосон судалгаа баримтгүй, тактик ажиллагааны төлөвлөлт хийхэд нөлөөлөх хүчин зүйл ихтэй, судалгааны чиглэл нарийн

тооцоологдоогүй, хамгаалах хүч хэрэгслийн хүчин чадал эрсдэл өндөртэй байна.

4. Аюулгүй байдлыг хангах мэргэжлийн сургалт, тусгай томилгоот шуурхай бүлгийн бэлтгэлжилт

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд зайлшгүй шаардлагатай хүлээн зөвшөөрдөг ч шуурхай бүлгийн бэлтгэл сургуулилт тогтмолжоогүй, ээлжийн бүрэлдэхүүнээс сонгон ажиллуулж байгаа нь бэлэн байдал хангахад хүндрэл учирдаг. Нэгдсэн удирдлага зохион байгуулалт дутагдалтай.

5. Галт зэвсэг, тусгай хэрэгслийн хангалт, нөөц, хүрэлцээ

Төвлөрсөн ангиудаас бусад албадад галт зэвсгийн хүрэлцээ хомс, нийт анги, албадын тусгай хэрэгслийн хангалт бүрэн шийдвэрлэгдээгүй, хамгаалалтын алба хаагч тусгай хэрэгсэл хэрэглэж хэвшээгүй.

6. Харуул хамгаалалтын тоног төхөөрөмжийн хүчин чадал

Хорих өрөөний хаалга, цоож, хамгаалалтын төмөр хаалт нэгдсэн стандартгүй хийгдсэн, гадна болон дотор гэрэлтүүлэг харилцан адилгүй, теле камерын хяналт тодорхой төвшинд сайжирсан хэдий ч эвдрэл гэмтэл байнга гардаг, шалган нэвтрүүлэх байрны үзлэгийн төхөөрөмжийг зохих журмын дагуу ашигладаггүй, стандарт бус байрны багтаамжаас хамаарч байршлыг зөв сонгоогүй, өвөл зуны улиралд тавих хяналтын цамхаг нэгдсэн байдлаар баригдаагүй, нөөц цахилгаан үүсгүүрийн хүчин чадал бага, зөвхөн гэрэлтүүлэг өгөх байдлаар шийдвэрлэгдсэн.

7. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа

Төвлөрсөн Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтантай хэдий ч мэргэжлийн сургууль төгссөн ажилтан цөөн байдаг. Үйлдвэрлэлтэй ангиудын аюулгүй ажиллагаанд шийдвэрлэгдээгүй хамгаалалт, хувцас хэрэглэл хангалтын асуудал дутагдалтай. Уурын зуух, цахилгаан, сан, тээвэр, агуулахын сахиул, гүний худгийн ус түгээгч, тогооч, жолооч, малчин гэх зэрэг ажлуудыг ялтанд хариуцуулдаг одоогийн байдал эрсдэл өндөртэй.

8. Эмнэлгийн үйл ажиллагаа, эрүүл ахуй, халдвар хамгаалал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяанд цагдан хоригдсон этгээд болон хоригдлыг эмчлэх нэгдсэн эмнэлэг Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна. Төвлөрсөн хорих анги, шийдвэр гүйцэтгэх албадын дэргэд хоригдлын эмнэлэгтэй, орон нутгийн цагдан хорих байрууд аймаг, сумдын нэгдсэн эмнэлэгт үзлэг оношилгоо хийлгэн эмнэлийн үйлчилгээ авч байна. Албан хаагчид төв, орон нутгийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлдэг. Алба хаагчийн эрүүл мэндийн судалгаа өндөр эрсдэлтэй гарсан. Зарим хорих ангийн "00", хашаан дотроо бохир ил байрлалтай, төвлөрсөн шугамгүйгээс хурдан дүүрч өвөл, зуны улиралд гараар зөөвөрлөн гаргадаг.

9. Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хүрэлцээ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд нийт 391 ширхэг тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас ажиллагаатай 364, ажиллагаагүй буюу актлах болсон 27 ширхэг тээврийн хэрэгсэл байна. Хуяглан хүргэлт, харуул хамгаалалтын тээврийн хэрэгсэл - 58 ширхэг буюу 14.8%-тай үүнээс

- 18 ширхэг буюу 31% нь сайн ажиллагаатай /хэвийн/
- 24 ширхэг буюу 41.3% нь дунд зэргийн ажиллагаатай
- 16 ширхэг буюу 27.5% нь муу ажиллагаатай байна.

Дийлэнх нь ОХУ-д үйлдвэрлэгдсэн УАЗ фургон авто машин бөгөөд шаардлага хангасан тусгай тоноглолгүй, зарим тохиолдолд аж ахуй үйлчилгээнд давхар ашиглаж байна.

Байгууллагын хэмжээнд хорих ангид нийтийн эмх замбараагүй байдал үүсэхэд ашиглах /усан хөөрөг, сум нэвтэрдэггүй, олон хүнийг тээвэрлэх тусгай тоноглол бүхий/ тусгай зориулалтын авто машин байхгүй, тээврийн хэрэгслийн үйлчилгээг ялтнууд голлон хийж байгаа нь аюулгүй байдлын шаардлага хангахгүй байна.

10. Ажиллаж, амьдрах орчин нөхцөл

Шинээр томилогдсон алба хаагчдыг хүлээн авах, тодорхой хугацаанд амьдрах албаны орон сууцны хүрэлцээ муу, төвөөс алслагдсан дэд бүтэцгүй анги, албаны байрууд нь галладаг багтаамж хүрэлцээгүй тохь, тухгүй байдгаас сэтгэл зүйд нөлөөлөн ажиллах урам зоригийг мохоодог. Тохитой дулаан байх бололцоог хайн байр хөлслөх нь санхүүгийн хувьд хүндрэл учруулдаг. Ажлын хамт олон зөв үлгэрлэх байдал учир дутагдалтай, шинэ ажилтан гэдгээр дээрэлхэх, жалга довны үзэл гаргаж сөрөг нөлөөлөл үзүүлдэг зэрэг нь тогтвор суурьшилтай ажиллах бус аль болох нөхцөл сайтай орчныг сонгож шилжилт хөдөлгөөн хийж байна.

11. Хүний нөөцийн бодлого

Ангийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор шилжилт хөдөлгөөний тодорхой төвшинд барьж мэргэшсэн чадварлаг боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах нь төвлөрсөн хорих ангиудын аюулгүй байдалд шууд нөлөөлөх хүчин зүйл болдог. Алба хаагчдыг томилохдоо нийгмийн асуудлыг цогцоор шийдвэрлээгүйгээс хүнд нөхцөлтэй анги албанд ажиллахгүй шантрах, гэр бүлийн байдал хоёр талд шийдэгдсэнээс гэр бүл салах улмаар ажлаа орхиход хүргэдэг. Ажилдаа дур сонирхолтой эсэхийг тодорхойлон, үр дүн гаргаж ажиллах чадвар чадамжийг өсгөх бодлого зохицуулалтыг тодорхой болгох, байгууллага, хамт олон, хувь хүний нэр хүндийг өсгөх чиглэлээр хийгдэх ажлууд учир дутагдалтай.

12. Мэдээлэл харилцаа холбооны аюулгүй байдал

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чадварлаг мэргэшсэн боловсон хүчин байхгүйгээс төв, орон нутгийн хорих анги, шийдвэр гүйцэтгэх албадад найдвартай хамгаалалтын систем цогц байдлаар шийдэгдээгүй байна. Удирдлагын зүгээс мэдээллийн аюулгүй байдлын учир холбогдлыг ойлгох байдал дутагдалтай, эрсдэлийг олж хардаггүй. Өндөр ур чадвартай ажилтныг ажиллуулахад цалин бага байдгаас төдийлөн сайн ажилтан ирдэггүй.

13. Ял эдлэгсдийн бүтэц, хүчний харьцаа

Төвлөрсөн хорих анги, цагдан хорих төвд хоригдогсад нь ихэвчлэн харуул хамгаалалтын хүч, хэрэгслээс илт давуу байдаг. Хүч хэрэгсэл тооны харьцуулалт стандартыг барьж байх шаардлагатай, гэтэл нөхцөл байдлаас хамаарч харилцан адилгүй байгаа нь өндөр эрсдэлийг бий болгодог. Хорих,

цагдан хорих байранд нийтийн эмх замбараагүй байдал үүсэхэд түүнийг таслан зогсоох боломж бүрдээгүй байна. Хоол, хүнсний аюулгүй байдал

Байгууллагын хэмжээнд хоногийн харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж буй алба хаагчид болон хоригдож буй ялтан, хоригдогчийн өдөр тутмын хоол, хүнсийг харьяа нэгжүүд бэлтгэн хүнсээр хангаж байна. Эрсдэлийн үнэлгээ хийгдэх явцад анхаарах асуудал нь албаны тогоочгүй ангид албан хаагчийн хоолыг ялтан бэлтгэн хийдэг нь хүнсний аюулгүйн баталгаагүй, сөрөг үр дагавар үүсэх магадлалтай. Хүнсний нийлүүлэлт, хадгалалт, хамгаалалтыг нягтлан шалгах ажил мэргэжлийн төвшинд хийгддэггүй.

14. Аюулгүй байдлыг хангах төсөв, зардлын зохицуулалт

Аюулгүй байдлын хэрэгцээ, шаардлагыг хангасан төсвийн зохих зүйл, төлөвлөлт тогтсон хэвшилгүй, тухайн жилийн онцлогоос хамаарч харилцан адилгүй зохицуулагдаж ирсэн. Аюулгүй байдлыг хангах зардлыг төсвийн зохих зүйлд тусгаж батлуулаагүйгээс шалтгаалж нөхцөл байдал хүндрэхэд төлөвлөгдөөгүй зардал гарч хууль зөрчихөд хүргэдэг зэрэг тулгамдаж буй асуудлыг дурдаж болох юм.

Дөрөв. Дүгнэлт, санал

Хорих байгууллагын хэмжээнд хийж хэрэгжүүлж буй аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа одоогийн байдлаар үр дүнгээ өгч байгаа нь хорих байгууллагын хэмжээнд гарч буй гэмт хэрэг, зөрчил, дутагдал буурч байгаатай холбон үзэж болох хэдий ч бодлогын түвшинд шийдвэрлэх шаардлагатай асуудлууд урган гарсаар байна.

Хорих байгууллагын харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангахад дараах тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэвэл үр дүнд хүрэх боломжтой гэж судлаачийн зүгээс үзэж байна. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зохицуулалтыг нэг мөр хэрэгжүүлэх;

2. Аюулгүй байдлыг хангах албан тушаалтны орон тоог нэмэгдүүлэх, /ажлын ачааллын жишиг норматив орон тоог нэмж оруулах/

3. Аюулгүй байдлыг хангах зардлыг төсвийн зохих зүйлд тусгаж батлуулаагүйгээс шалтгаалж нөхцөл байдал хүндрэхэд төлөвлөгдөөгүй зардал гарч хууль зөрчихөд хүргэдэг тул аюулгүй байдлыг хангахад шаардагдах төсвийг тооцоолон байгууллагын төсөвт суулгах,

4. Онцгой нөхцөл бий болсон үед ажиллах төлөвлөлт, төлөвлөгөөг нэгдсэн байдлаар боловсруулж, төлөвлөгөөний үндсэн агуулгын хүрээнд тухайн орон нутаг, хорих ангийн онцлогтой уялдуулан боловсруулах,

5. Анги, албадад галт зэвсгийн хүрэлцээ хомс, нийт анги, албадын тусгай хэрэгслийн хангалт бүрэн шийдвэрлэгдээгүй, хамгаалалтын алба хаагч тусгай хэрэгсэл хэрэглэж хэвшээгүй тул сургалт, дадлагыг хэвшүүлэх, галт зэвсэг, тусгай хэрэгслийн хангалт хийх;

6. Байгууллагын хэмжээнд өндөр хүчин чадал бүхий авто машин, хорих ангид нийтийн эмх замбараагүй байдал үүсэхэд ашиглах /усан хөөрөг, сум нэвтэрдэггүй, олон хүнийг тээвэрлэх тусгай тоноглол бүхий/ тусгай зориулалтын авто машин байхгүй тул энэ төрлийн тээврийн

хэрэгслийг нэн тэргүүнд байгууллагын хэрэгцээнд нэвтрүүлэх зэрэг саналтай байна.

Ашигласан эх сурвалж

1. А.Сүхбаатар. Аюулгүй байдал, батлан хамгаалах, цэргийн стратеги, гадаад, дотоод бодлогын үндсэн асуудал. УБ., 2004.

2. Ж.Бор. Жижиг улс ба Үндэсний аюулгүй байдал. Жижиг улсын аюулгүй байдал. Өнөө ирээдүй эмхэтгэл. УБ., 2010.

3. Ц.Очгэрэл. Хорих байгууллагын аюулгүй байдал. УБ. 2017. 36 дахь тал

4. Ж.Энхбаяр. Аюулгүй байдлын олон талт асуудал. УБ., 2007. 8 дахь тал

5. Монгол улсын Их хурлын 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоол, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УИХ-ын Тамгын газрын хэвлэх цех., УБ., 2010.